



МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон
тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 136 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн ажиллах журам”-ын 4.1, 4.2, 4.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Барилга, хот байгуулалтын салбарын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төсөвт тусган, хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл /С.Магнайсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 227 дугаар, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд нэмэлт оруулах тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 180 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Ц.ДАВААСҮРЭН

152310090

Барилга, хот байгуулалтын сайдын
2023 оны 02 дугаар сарын 10 ны
өдрийн 3.0 тушаалын хавсралт



**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ
ОРОН ТООНЫ БУС ДЭД ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга: Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;

Дэд дарга: Барилга, хот байгуулалтын яамны Барилга, барилгын материалын
үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

Гишүүд:

Барилга, хот байгуулалтын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын
Орон сууцны санхүүжилтийн хэлтсийн Орон сууцны төлөвлөлт,
хэрэгжилт хариуцсан шинжээч;

Барилга, хот байгуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын
газрын Төсвийн нэгдсэн төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч;

Барилга, хот байгуулалтын яамны Статистик, мэдээллийн
технологийн хэлтсийн Салбарын суурь судалгаа, статистик
мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн;

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн
бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хөгжлийн бэрхшээлтэй
иргэдийн хууль тогтоомж, нийгмийн оролцооны асуудал хариуцсан
мэргэжилтэн /тохиролцсоноор/;

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн
бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хүртээмжийн асуудал
хариуцсан мэргэжилтэн /тохиролцсоноор/;

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга
/тохиролцсоноор/;

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Захиргаа,
удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга;

“Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын Норм, нормативын хэлтсийн
дарга;

“Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын Барилга байгууламжийн
зураг төслийн магадлалын хэлтсийн дарга;

“Монголын барилгачдын нэгдсэн холбоо” ТББ-ын гүйцэтгэх захирал
/тохиролцсоноор/;

“Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбоо” ТББ-ын гүйцэтгэх захирал /тохиролцсоноор/;

“Монголын барилгын инженерүүдийн холбоо” ТББ-ын гүйцэтгэх захирал /тохиролцсоноор/;

“Монголын барилгын гүйцэтгэгч байгууллагуудын холбоо” ТББ-ын гүйцэтгэх захирал /тохиролцсоноор/;

“Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хороо”-ны ерөнхий зохицуулагч /тохиролцсоноор/;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгууллагуудын “Шүхэрт” нэгдсэн бодлогын ерөнхий зөвлөлийн ерөнхийлөгч /тохиролцсоноор/;

“Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо” ТББ-ын тэргүүн /тохиролцсоноор/;

“Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо” ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн захирал /тохиролцсоноор/;

“Монголын сонсголгүй иргэдийн байгууллагуудын нэгдсэн холбоо” ТББ-ын тэргүүн /тохиролцсоноор/.

Нарийн бичгийн
дарга:

Барилга, хот байгуулалтын яамны Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Барилгын зураг төсөл, төлөвлөлтийн бодлого, зохицуулалт хариуцсан шинжээч.

-----***-----